



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



ХӨГЖИМ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ.
- (*) тэмдэгтэй даалгавруудыг хөгжим болон дуу сонссоны дараа гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн хариултаас зөвхөн нэг хариултыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

***Ж.Мэнд-Амар “Хан хөхийн уянга” бүтээлийг сонсоод 1-4 дүгээр даалгаврыг гүйцэтгээрэй.**

1. *Зохиол хэдэн хэсэгтэй байна вэ? Тохирохыг сонгоно уу.

- A. А В С B. А В
 C. А В А D. А В С D

2. *Сонссон зохиолын сүүлийн хэсгийн аялгууны хурд чинийхээр ямар байсан бэ? Тохирохыг сонгоно уу.

- A. Дунд зэрэг B. Хурдан C. Хурдавтар D. Тайван

3. *Чиний бодлоор зохиолын сүүлийн хэсгийн аялгууны ноот бичлэг аль нь байна вэ? Тохирохыг сонгоно уу.

- A. 
- B. 
- C. 
- D. 

4. *Зохиолын 2 дугаар хэсгийн утга санааг илэрхийлэхэд өгсөн зургуудаас аль нь тохирох вэ?

- A. 
 B. 
 C. 
 D. 

***Монгол ардын дуу “Дөрвөн уул”-ыг сонсоод 5-8 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.**

5. *Сонсоод 1 дүгээр хувилбарын аялгууны хурдыг тодорхойлоорой.

А. Дунд зэрэг В. Хурдан С. Маш хурдан D. Удаан

6. *Ноот бичлэгийг ажиглаад дууны айзам хэмжээг тодорхойлоорой.



A. $\frac{2}{4}$ B. $\frac{4}{4}$ C. $\frac{3}{4}$ D. $\frac{5}{4}$

7. *Сонсоод 1 дүгээр хувилбар хөөмийн ямар төрөл болохыг сонгоорой.

А. Хархираа В. Шахаа С. Исгэрээ D. Амаар таших

8. *Аялгуу хэдэн хэсгээс бүтсэн байна вэ? Тохирохыг сонгоорой.

A. А В B. А В С А1
 C. А В С D. А В А





9. Монгол ардын уртын дууг бүтцээр нь зөв ангилсан хувилбарыг сонгоно уу.

А. Боржигон, Бэсрэг, Төв халх В. Бэсрэг, Айзам, Суман
 С. Бэсрэг, Айзам, Боржигон D. Төв халх, Суман, Боржигон

10. Домгийн сэдэвтэй, тухайлсан өгүүлэмж дүртэй, найраглал мэт урт, товшуур болон хуураар хамсран хөгжимддөг төрөл аль вэ?

А. Ерөөл В. Туульс магтаал С. Хүндэтгэл магтаал D. Бий биелгээ

11. Зургаас монгол ардын дуулах урлагийг илэрхийлснийг сонгоорой.

A.  B.  C.  D. 

12. Тахимцаа суултаар сууж, далыг ээлжлэн газар цохилон, толгойг хөдөлгөхгүй, мөрийг ээлжлэн газар цохилон биелэх нь ямар биелгээний онцлог вэ? Сонгоно уу.

А. Торгууд В. Баяд С. Урианхай D. Захчин

13. Дараах хөгжмийн зэмсэг аль бүлэгт хамаарах вэ? Зөв харгалзуулсан хувилбарыг сонгоно уу.

1. 	а. Үлээвэр хөгжим
2. 	б. Чавхдаст товшвор
3. 	в. Чавхдаст нумт
4. 	г. Чавхдаст цохивор

A. 1б 2в 3г 4а

B. 1в 2б 3г 4а

C. 1в 2г 3б 4а

D. 1б 2г 3в 4а

14. Язгуур бий биелгээний үндсэн суултыг нэршилтэй нь зөв харгалзуулсныг сонгоно уу.

1.



а. Цомцойх суудал

2.



б. Хагас тахимцаа суудал

3.



в. Хаан суудал

4.



г. Бүтэн тахимцаа суудал

A. 1а 2в 3б 4г

B. 1б 2г 3в 4а

C. 1а 2г 3в 4б

D. 1б 2в 3а 4г